



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 4 сарын 29 өдөр


Дугаар 8/34

Улаанбаатар хот

Г Төрийн албан хаагчийн сургалтын
хөтөлбөр батлах тухай Г

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.6, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1 дэх заалт, Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар буй болгох хөтөлбөр", тус Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 5 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.
2. "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар болон орон нутаг дахь газрын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөх, шаардлагатай зардлыг төсөвт тусгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нэгдсэн удирдлага, хамтын ажиллагааны алба /Г.Мөнхцэцэг/-д даалгасугай.



ДАРГА

А.ХҮРЭЛШАГАЙ

0000359



Газрын харилцаан, геодези, зураг зүйн газрын
даргын 2015 оны 7 дугаар тушаалын хавсралт

**ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ТӨРИЙН АЛБАН
ХААГЧИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1 дэх заалт, Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар буй болгох хөтөлбөр", байгууллагын стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, албан хаагчидтай байгуулсан Ур дүнгийн гэрээ, түүний биелэлтийг дүгнэсэн байдал, судалгаа зэрэг нь энэхүү хөтөлбөрийн үндэслэл болно.

2. Газрын харилцааны салбарын төрийн албан хаагчид буюу агентлагийн албан хаагчид, орон нутаг дахь газрын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинэ мэдлэг чадвар бий болгох замаар мэргэшсэн, ур чадвар бүхий хамт олныг төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

3. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1. Албан хаагчийг эрхэлсэн ажил үүргээ амжилттай гүйцэтгэх мэдлэг олж авах, мэдээлэл солилцох онол, арга зүйд суралцуулах;

3.2. Албан хаагчдыг мэргэшүүлж, тогтвортой суурьшилтай ажиллуулах;

3.3. Хөтөлбөрийн 3.1, 3.2-т заасан зорилтыг хэрэгжүүдэх замаар байгууллагыг хөгжүүлэх салбарын бодлогын хэрэгжилтийг дэмжих.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1. Ил тод, хариуцлагатай байх – мэдлэг чадварыг сайжруулах, бий болгох үйл явцыг нээлттэй ил тод байдлаар хэрэгжүүлж, мэдлэг чадвар олгох үйл ажиллагаанд албан хаагчийн оролцоог хариуцлагажуулна.

3.1.5. Албан хаагчдыг ажлын байрны, зайн, гадаадын болон сургалтын мэргэжлийн байгууллагаас зохион байгуулдаг танхимын сургалтын аль ч хэлбэрээр сургалтад хамруулж болно.

3.1.6. Гадаад улсад сургалтад суралцах бол гадаад хэлний мэдлэг, ажилласан жил, туршилга, ажлын үр дүнг болон одоо эрхэлж байгаа ажлын чиг үүрэг тухайн сургалтын хөтөлбөртэй нийцэж буй эсэхийг харгалзана.

3.1.7. Энэхүү хөтөлбөрийн 3.1.6-д зааснаас бусад сургалтад төрийн зардлаар суралцах тохиолдолд ажилласан жил, туршилга, ажлын үр дүнг болон одоо эрхэлж байгаа ажлын чиг үүрэг тухайн сургалтын хөтөлбөртэй нийцэж буй эсэхийг харгалзана.

3.1.8. Сургалтад хамрагдах хугацаанд цалинтай чөлөө олгох, тусlamж үзүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

3.1.9. Байгууллагын дотор өдөр тутмын ажил үүргээ гүйцэтгэх явцад суралцах боловжийг олгоно.

3.1.10. Үр чадвар, ажлын туршилгад тулгуурлан тодорхой хугацааны дотор шинэ ажил, онц чухал үүрэг даалгавар гүйцэтгүүлэх, боловсруулахаар томилон ажиллуулах замаар мэдлэг, үр чадварыг нь нэмэгдүүлнэ.

3.1.11. Үр чадвар, ажлын туршилгыг нэмэгдүүлэх, байгууллагын стратеги, зорилт, бүтэц зохион байгуулалтын талаарх мэдлэгийг дээшлүүлэхээр нэгж хооронд эсвэл нэгж дотор нь сэлгэн ажиллуулна.

3.2. Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.2.1. Жил бүр албан хаагчдын боловсрол, хамрагдсан сургалтын талаар судалгааг гарган, ажлын байрны чиг үүрэгтэй уялдуулан сургалтын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөнд нэгж бүрээс санал авах ба шаардлагатай зардлыг төсөвт тусгуулна.

3.2.2. Төрийн захиргааны эрхэлсэн түшмэл, ахлах түшмэлийн ангилалын албан хаагчийг төрийн удирдлагын мэргэшсэн магистрын зэрэг олгох сургалтад, дэс